

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/161/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Чингис хот  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 91913204 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа  
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2025.02.24

№

247

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТШИРЭЭТ  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ц.ЦОГЗОЛМАА  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 1,315,286.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 276,910.3 мянган төгрөгийн санхүүжилт, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 1,225.8 мянган төгрөг нийт 1,593,422.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, 1,516,492.2 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 12,225.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 786,717.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 160,161.7 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 625,555.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэл 93.0 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

232500247

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>254,058,112.05</b>	<b>336,254,253.30</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>167,775,577.14</b>	<b>233,372,110.99</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>167,775,577.14</b>	<b>233,372,110.99</b>
3121	Төгрөг	167,775,577.14	233,372,110.99
31211	Төрийн сангийн харилцах	167,775,577.14	233,372,110.99
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>86,282,534.91</b>	<b>102,882,142.31</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>40,759,398.76</b>	<b>46,386,998.76</b>
<b>35110</b>	<b>Тусгай зориулалттай материал</b>	<b>40,759,398.76</b>	<b>46,386,998.76</b>
35300	Бэлэн бүтээгдэхүүн	15,378,770.00	19,002,910.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>30,144,366.15</b>	<b>37,492,233.55</b>
35410	Бичиг хэргийн материал	1,446,000.00	1,499,000.00
<b>35420</b>	<b>Аж ахуйн материал</b>	<b>4,219,000.00</b>	<b>4,219,000.00</b>
35440	Түлш, шатах тослох материал	1,574,400.00	448,800.00
35460	Хүнсний материал	1,443,824.00	741,002.00
35470	Бусад хангамжийн материал	21,461,142.15	30,584,431.55
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,440,192,159.91</b>	<b>5,257,356,953.21</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,440,192,159.91</b>	<b>5,257,356,953.21</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,383,870,159.91</b>	<b>5,201,034,953.21</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,476,781,293.74	5,476,781,293.74
<b>39202</b>	<b>Хуримтлагдсан элэгдэл</b>	<b>(311,256,431.34)</b>	<b>(499,987,294.65)</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	206,805,681.08	255,108,401.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,227,940.85)	(89,703,584.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,984,532.00	93,494,532.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,678,083.04)	(57,119,502.63)
39217	Ном	22,461,108.32	22,461,108.32
393	Биет бус хөрөнгө	56,322,000.00	56,322,000.00
39301	Програм хангамж	67,000.00	67,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(67,000.00)	(67,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	56,322,000.00	56,322,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,694,250,271.96</b>	<b>5,593,611,206.51</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>18,496,427.41</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>18,496,427.41</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	<b>18,496,427.41</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	18,496,427.41
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,694,250,271.96</b>	<b>5,575,114,779.10</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,694,250,271.96</b>	<b>5,575,114,779.10</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>295,438,231.39</b>	<b>295,438,231.39</b>
<b>51101</b>	<b>Өмч: - төрийн</b>	<b>295,438,231.39</b>	<b>295,438,231.39</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>4,945,468,207.07</b>	<b>4,826,332,714.21</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,725,663,019.11	4,887,381,603.23
<b>51220</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>3,219,805,187.96</b>	<b>(61,048,889.02)</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	453,343,833.50	453,343,833.50
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,694,250,271.96</b>	<b>5,593,611,206.51</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,337,651,111.50</b>	<b>1,639,573,309.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,305,030,211.50</b>	<b>47,376,809.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,305,030,211.50</b>	<b>47,376,809.40</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,305,030,211.50	47,376,809.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,815,800.00	1,120,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	105,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,303,214,411.50	46,151,009.40
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,032,620,900.00</b>	<b>1,592,196,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,032,620,900.00</b>	<b>1,592,196,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	184,132,800.00	276,910,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	841,488,100.00	1,315,286,200.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	7,000,000.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,102,566,549.64</b>	<b>1,700,622,198.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,102,566,549.64</b>	<b>1,700,622,198.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,049,301,425.87</b>	<b>1,637,088,290.03</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>632,902,478.66</b>	<b>958,228,168.87</b>
210101	Үндсэн цалин	462,988,291.55	655,607,414.54
210102	Нэмэгдэл	150,816,097.11	282,342,204.33
210104	Урамшуулал	19,098,090.00	20,278,550.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,786,683.94</b>	<b>114,630,950.68</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,798,650.29	81,246,756.20
210202	Тэтгэмжийн даатгал	6,166,679.20	9,084,031.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,841,715.00	4,462,815.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,131,380.39	3,954,018.63
210205	Эрүүл мэндийн даатгал	10,848,259.06	15,883,328.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>163,086,756.23</b>	<b>262,690,051.61</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,065,161.23	13,399,502.65
210302	Түлш, халаалт	150,021,595.00	240,590,548.96
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	8,700,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,768,440.00</b>	<b>00.00</b>
210401	Бичиг хэрэг	739,500.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,972,040.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	1,056,900.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>55,851,660.00</b>	<b>68,018,042.00</b>
210502	Хоол, хүнс	55,851,660.00	68,018,042.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>926,500.00</b>	<b>432,000.00</b>
210604	Урсгал засвар	926,500.00	432,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,623,000.00</b>	<b>17,583,903.81</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,815,800.00	1,120,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,807,200.00	16,463,103.81
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>118,355,907.04</b>	<b>215,505,173.06</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,561,660.00	29,744,680.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,948,300.00	6,199,170.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	80,845,947.04	179,561,322.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>53,265,123.77</b>	<b>63,533,908.39</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>45,019,080.00</b>	<b>51,308,160.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,019,080.00	51,308,160.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>8,246,043.77</b>	<b>12,225,748.39</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,246,043.77	12,225,748.39
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>3,235,084,561.86</b>	<b>(61,048,889.02)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>15,279,373.90</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	15,279,373.90	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-15,279,373.90</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>3,219,805,187.96</b>	<b>(61,048,889.02)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,027,436,700.00</b>	<b>1,593,422,300.00</b>
110002	Үйл ажиллагааны орлого		
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,815,800.00</b>	<b>1,225,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,815,800.00</b>	<b>1,225,800.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,815,800.00	1,225,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,815,800.00	1,120,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	105,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,025,620,900.00</b>	<b>1,592,196,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>841,488,100.00</b>	<b>1,315,286,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	841,488,100.00	1,315,286,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>184,132,800.00</b>	<b>276,910,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	184,132,800.00	276,910,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,021,775,446.60</b>	<b>1,527,825,766.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,021,775,446.60</b>	<b>1,527,825,766.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>959,953,502.83</b>	<b>1,460,667,717.76</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>621,077,101.51</b>	<b>948,957,698.60</b>
210101	Үндсэн цалин	451,162,918.16	642,259,224.66
210102	Нэмэгдэл	150,816,094.87	279,379,320.32
210104	Урамшуулал	19,098,088.48	27,319,153.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>79,612,061.09</b>	<b>104,724,993.54</b>
210201	Тэтгэврийн даатгал	54,964,048.87	71,340,799.08
210202	Тэтгэмжийн даатгал	6,185,393.72	9,084,031.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,899,275.09	4,462,815.74
210204	Ажилгүйдлийн даатгал	1,201,895.30	3,954,018.63
210205	Эрүүл мэндийн даатгал	12,361,448.11	15,883,328.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>160,886,756.23</b>	<b>261,790,051.61</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,065,161.23	12,101,640.63
210302	Түлш, халаалт	147,821,595.00	240,988,410.98
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	8,700,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>47,720,184.00</b>	<b>67,315,220.00</b>
210502	Хоол, хүнс	47,720,184.00	67,315,220.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,000,000.00</b>	<b>2,999,500.00</b>
210604	Урсгал засвар	15,000,000.00	2,999,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,623,000.00</b>	<b>22,968,903.81</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,815,800.00	1,120,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,807,200.00	21,848,103.81
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,034,400.00</b>	<b>51,911,350.20</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,334,000.00	42,189,580.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,700,400.00	9,721,770.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,821,943.77</b>	<b>67,158,048.39</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>53,575,900.00</b>	<b>54,932,300.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,575,900.00	54,932,300.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>8,246,043.77</b>	<b>12,225,748.39</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,246,043.77	12,225,748.39
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>5,661,253.40</b>	<b>65,596,533.85</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>30,252,000.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,252,000.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>30,252,000.00</b>	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,252,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(30,252,000.00)</b>	≡
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(24,590,746.60)</b>	<b>65,596,533.85</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>167,775,577.14</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>167,775,577.14</b>	<b>233,372,110.99</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>					
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	295,438,231.39	453,343,833.50	5,028,877,430.61	-	<b>5,777,659,495.50</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			(83,409,223.54)		<b>(83,409,223.54)</b>
<b>C08</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	295,438,231.39	453,343,833.50	<b>4,945,468,207.07</b>	-	<b>5,694,250,271.96</b>
<b>D01</b>	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	295,438,231.39	453,343,833.50	<b>4,945,468,207.07</b>	-	<b>5,694,250,271.96</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(58,086,603.84)		<b>(58,086,603.84)</b>
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	295,438,231.39	453,343,833.50	4,887,381,603.23	-	<b>5,636,163,668.12</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			(61,048,889.02)		<b>(61,048,889.02)</b>
<b>D09</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	295,438,231.39	453,343,833.50	<b>4,826,332,714.21</b>	-	<b>5,575,114,779.10</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,762,899,100.00</b>	<b>1,515,600,017.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,762,899,100.00</b>	<b>1,515,600,017.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,707,966,300.00</b>	<b>1,460,667,717.76</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,134,742,200.00</b>	<b>948,957,698.60</b>
210101	Үндсэн цалин	722,644,800.00	642,259,224.66
210102	Нэмэгдэл	387,462,000.00	279,379,320.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,635,400.00	27,319,153.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>141,842,800.00</b>	<b>104,724,993.54</b>
210201	Тэтгэврийн даатгал	96,453,100.00	71,340,799.08
210202	Тэтгэмжийн даатгал	11,347,500.00	9,084,031.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,673,700.00	4,462,815.74
210204	Ажилгүйдлийн даатгал	5,673,700.00	3,954,018.63
210205	Эрүүл мэндийн даатгал	22,694,800.00	15,883,328.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>273,910,300.00</b>	<b>261,790,051.61</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,465,000.00	12,101,640.63
210302	Түлш, халаалт	253,445,300.00	240,988,410.98
210303	Цэвэр, бохир ус	10,000,000.00	8,700,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>67,315,600.00</b>	<b>67,315,220.00</b>
210502	Хоол, хүнс	67,315,600.00	67,315,220.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>2,999,500.00</b>
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,999,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>25,372,100.00</b>	<b>22,968,903.81</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,120,800.00	1,120,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,251,300.00	21,848,103.81
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>61,783,300.00</b>	<b>51,911,350.20</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,061,200.00	42,189,580.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,722,100.00	9,721,770.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,932,800.00</b>	<b>54,932,300.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>54,932,800.00</b>	<b>54,932,300.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,932,800.00	54,932,300.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,762,899,100.00</b>	<b>1,581,196,551.61</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,485,988,800.00</b>	<b>1,315,286,200.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,485,988,800.00	1,315,286,200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>276,910,300.00</b>	<b>264,684,551.61</b>
132001	Орон нутгийн төсвөөс	276,910,300.00	264,684,551.61
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	1,225,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,120,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		105,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>167,775,577.14</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>233,372,110.99</b>

## **ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 160,161.7 мянган төгрөгийн төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Үүнд:

Цалингаас суутгасан 3,745.6 мянган төгрөгийн шимтгэл, 4,844.8 мянган төгрөгийн татвар, 9,905.9 мянган төгрөгийн ажил олгогчийн төлөх шимтгэлийн тооцоог хийж, бүртгэлд тусгаагүй байсныг өглөгөөр бүртгэж залруулсан.

Цалингийн тооцоогоор үүссэн 130.6 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй орхигдуулсныг тооцоо хийж, авлагаар бүртгүүлэв.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл тодруулгын тайлангийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлээс 58,086.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг өмнөх үеийн үр дүнд, барилга байгууламж дансанд бүртгэлтэй 2 хөрөнгөнд 81,908.1 мянган төгрөгийн элэгдэл бодоогүй алдааг тайлант оны зардлаар бүртгэж залруулсан.

Түрээсийн номын орлого төвлөрүүлэхээр худалдан авсан 1,540.0 мянган төгрөгийн пос машины төхөөрөмжийг хөрөнгөнд бүртгээгүй шууд зардалд бүртгэснийг хөрөнгөөр бүртгэв.

Аудитаар нийт 626,555.9 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 626,555.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

### **3.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### **3.2 Албан шаардлага**

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалингийн санг 5,435.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих мэдээллийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 275,410.3 мянган төгрөгийн 9 орлого, 244,938.4 мянган төгрөгийн 10 зарлагын мөнгөн гүйлгээ, 100,772.1 мянган төгрөгийн 2 тендерийг мэдээлээгүй зөрчил илэрсэн.

### **3.3 Зөвлөмж**

Зөвлөмж өгөгдөөгүй.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдэл зөрүүтэй байгуулсан	1	139,994.7	1	139,994.7			1	139,994.7				
Цалингийн өглөг дутуу бүртгэсэн	1	18,496.4	1	18,496.4			1	18,496.4				
Цалингийн авлагыг бүртгээгүй	1	130.6	1	130.6			1	130.6				
Хөрөнгийг шууд зардалд бүртгэсэн	1	1,540.0	1	1,540.0			1	1,540.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>160,161.7</b>	<b>3</b>	<b>160,161.7</b>	-	-	<b>3</b>	<b>160,161.7</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Цалинг НДШ-ийн тайланд дутуу тайлагнасан	1	5,435.1			1	5,435.1							
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>5,435.1</b>			<b>1</b>	<b>5,435.1</b>							

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл дутуу байршуулсан	1	621,120.8			1	621,120.8		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>621,120.8</b>			<b>1</b>	<b>621,120.8</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>621,120.8</b>			<b>1</b>	<b>621,120.8</b>		
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>621,120.8</b>			<b>1</b>	<b>621,120.8</b>		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 109-ХЭА-2025/161/НА-СТА-ТШЗ  
А 2370448 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 275,410.3 мянган төгрөгийн орлого, 244,938.4 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээ, 100,772.1 мянган төгрөгийн 2 тендерийн мэдээллийг ил тод мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ц.Цогзолмаад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Б.АРИУНАА

232504109



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 22

Дугаар 110-ХЭА-2025/161/НА-СТА-ТШЗ  
А2370448

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд бодогдсон цалингийн санг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 5,435.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө" гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалингийн санг шимтгэлийн тайланд дутуу тайлагнадаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ц.Цогзолмаад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Б.АРИУНАА